

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 02

№ 25/ТУЗ/20

Улаанбаатар хот

“ Сонирхлын зөрчил бүхий хэлцэл хийх
зөвшөөрөл олгох тухай ”

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, Монложистикс Холдинг ХК-ийн дүрмийн 7.14.19, Монложистикс Холдинг ХК-ийн Төлөөлөн Удирдах 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн ээлжит бус хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Монложистикс Холдинг ХК-иас группийн охин компаниудтай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хуралд танилцуулсан Хавсралт №1-т заасан үнийн нөхцөлийн дагуу “Менежментийн үйлчилгээний гэрээ” байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ, хэлцэл хийх болон холбогдох бусад баримт бичигт Монложистикс Холдинг ХК-ийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Г. Хишигбат/-д олгосугай.
3. Энэхүү тогтоолыг Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргэхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга /Ц. Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГАНЗОРИГТ

monlogistics
HOLDING

"Монложистикс Холдинг" ХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн 2025 оны 04 сарын 02 -ны өдрийн
№ 25/ТУЗ/20 тогтоолын Хавсралт №1

№	Монложистикс Холдинг ХК-тай Менежментийн үйлчилгээний гэрээ байгуулах охин компанийн нэр	Гэрээний үнийн дүн
1	Монложистикс Ворлдвайд ХХК	159,000,000 төгрөг
2	Монложистикс Транзит ХХК	52,000,000 төгрөг
3	Монложистикс Карго ХХК	3,000,000 төгрөг
4	Монложистикс Тракинг ХХК	30,000,000 төгрөг
5	Каус Аустралис ХХК	15,000,000 төгрөг
6	Монложистикс Экспресс ХХК	13,800,000 төгрөг
7	Монложистикс Экүйпментс ХХК	40,000,000 төгрөг
8	Төв Азийн Зам ХХК	9,000,000 төгрөг
Нийт (гурван зуун хорин нэгэн сая найман зуун мянга)		321,800,000 төгрөг

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ГАНЗОРИГТ

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 02

№ 25/ТУЗ/19

Улаанбаатар хот

“Эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг шинэчлэн батлах тухай”

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 84 дүгээр зүйлийн 84.1, 84.2 дахь заалт, Монложистикс Холдинг ХК-ийн дүрмийн 9.1, Монложистикс Холдинг ХК-ийн Төлөөлөн Удирдах 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн ээлжит бус хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

“Монложистикс Холдинг” ХК-ийн дараах албан тушаалтнуудыг эрх бүхий албан тушаалтанд тооцсугай. Үүнд:

- 1.1 ТУЗ-ийн гишүүн;
- 1.2 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;
- 1.3 Гүйцэтгэх захирал;
- 1.4 Ерөнхий нягтлан бодогч;
2. Энэхүү тогтоол батлагдсан өдрөөс Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн №24/ТУЗ/12 тоот “Эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг шинэчлэн батлах тухай” тогтоолыг хүчингүйд тооцсугай.
3. Энэхүү тогтоолыг Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж болон олон нийтэд зохих журмын дагуу мэдээлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Ц.Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ГАНЗОРИГТ
HOLDING